

9

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙ ДАХЬ БЭЛЧЭЭР, НУТГИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Ц. Цэвээн

Монгол орны нутгийн талбайн хэмжээг эрдэмтэд, зарим эрдэм шинжилгээний байгууллагууд янз бүрээр тэмдэглэсэн байдаг. Тухайлбал Э.М Мурзаев 1531000 кв.км гэсэн бол А.А. Юнатов 1950 онд 1565000 кв. км юм гэжээ. Монгол улсын шинжлэх ухааны Академийн Газар зүй Цэвдэг Судлалын Хүрээлэн 1962 онд 1596963 кв. км талбайтай гэж тогтоосон байна. БНМАУ-ын Хөдөө аж ахуйн яамны Газар зохион байгуулах хэлтэс 1975 онд 1565118 кв.км газар нутагтай гэж тогтоосныг одоо албан ёсоор мөрдөж байгаа юм. Эдгээр талбай нь тус орны уул нуруу, хотгор гүдгэрийн нийлбэр талбайг харгалзахгүйгээр картын хэвтээ тусгалаас (проект) планиметрээр хэмжиж тодорхойлсон учир уулсын зөвхөн суурийн талбай орсон байна. Гэтэл Алтай, Хангай, Хэнтийн үргэлжилсэн уул нурууд түүний салбар уулс, мөн гүвээ толгодын гадаргуу зэрэг (хавтгай дээрх хавтгай)-ийг нэмж манай зарим эрдэмтдийн тооцоолсноор 2 сая гаруй кв.км талбай бүхий болно гэсэн ойролцоолсон хэмжээ байдаг. Энэ газар нутаг нь Төв Азийн Зүүн хойд хэсэгт Сибирийн тайга, Төв Азийн цөлийн бүсийн хооронд орших бөгөөд хойд өргөрөгийн $42^{\circ} 32'$ -аас $52^{\circ} 15'$ -ийн хооронд оршиж баруунаас зүүнээ хүртэл 2392 км хойноосоо урагш 1259 км сунаж тогтсон далайн түвшинөөс дээш дунджаар 1580 м өргөгдсөн хамгийн өндөр цэг нь Монгол Алтайн нурууны ноён оргил Алтай Таван Богдын Хүйтэн уул далайн түвшинээс дээш 4374 м. Хамгийн нам цэг нь Дорнод Монголын тал дахь Хөх нуурын хотгор далайн түвшинээс дээш 560 метр юм.

Нутгийн гадаргуугийн ихэнхи нь буюу 80 гаруй хувь нь далайн түвшингээс дээш 1000-3000 м өргөгдсөн байдаг. Монгол улсын хилийн эргэн тойрон урт 8160 км 960 м бөгөөд Оросын Холбооны улстай 3485 км.

940 м, БНХАУ-тай 4675 газраар хиллэдэг. Тэнгис далайгаас ихэд алслагдсан болохоор эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай юм. Тийм боловч Монгол хүн эх орондоо хайртай бөгөөд анхдагч амь нь эх орон, удаах амь өөрийнх байдгийг бидний дээдсүүдийн эх орноо хамгаалан тэмцэж ирснийг гэрчлэх буурал түүхийн шаралсан хуудсууд нотолдог.

Монгол хүн бүрийн сэтгэл, оюунд мөнх хадаатай явдаг ойлголтуудын нэг бол нутаг юм. Нутгийн нэрийг өөрийн нэрээс өндөрт тавьж түүнийг ариун байлгах эрмэлзэл хүн бүрт байдгийг учиглан үзэхүй Монголчуудын эх оронч сэтгэлгээний анхдагч “цагаан толгой” үүнээс эхтэй гэж үзэх үндэстэй.

Алсад зорин явагчдад аав, ээж, төрөл төрөгсөд, ус нутгийнхан нь нутгийн нэрээ өндөрт өргөн хийморьтой яваарай гэж захидаг нь хүн, байгаль хоёрын хүйн холбоог илэрхийлсэн монгол сургамж юм.

Бид энэхүү сэдвээр монгол улсын бэлчээр нутгийн ашиглалтын зарим асуудлыг авч үзэхээр зорив.

Дэлхийн улс орнууд хамгийн тохиромжтой аж ахуйн салбараар газар нутгаа эдэлбэрлэдэг зүй тогтолтой. Монгол орны газар нутаг нь нэлэнхүй газар тариалан эрхлэх боломжгүй, харин мал аж ахуйг бэлчээрийн хэлбэрээр нэлэнхүй эрхлэн хөтлөх боломжтой бөгөөд хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 90 гаруй хувийг бэлчээрийн талбай эзэлдэг.

Тиймээс ч Монгол нутагт өнө эртнээс тухайлбал Шинэ чулуун зэвсгийн үеэс амьтдыг гаршуулж, гэршүүлэн улмаар бэлчээрийн мал аж ахуй болгон хөгжүүлж өнөө хүртэл түүнийгээ эрхлэн хөтлөж иржээ.

Монгол улсын эдийн засаг, аж ахуйн үндсэн салбаруудын нэг бэлчээрийн мал аж ахуйг оршин тогтноулж, эрхлэн хөтлөхийн үндэс болсон бэлчээр, нутгийн талаар эрт цагаас эдүгээг хүртэл өрнө дорнын орнуудын болон манай орны олон эрдэмтэн судлаачид бүтээлдээ тусгасан нь цөөнгүй. Тухайлбал 13-р зууны үед Европын Марко Поло, Плана Карпини, Гильем де Рубрик мөн Персийн түүхч Рашид Ад Дин, хожуу үед Зөвлөлт, Оросын эрдэмтэд Б.Я.Владимирцов, И.А.Майский, В.Грайворонский, Г.С.Матвеева, Э.Мурзаев, А.Юнатов, С.К.Рощин, С.Денисов, Д.Симуков нар болон манай орны хувьд алдарт “Монголын нууц товчоо”, “Лу алтан товчоо”-оос эхлээд Б.Тогтохтөр, В.Инжинаш, Б.Цэвэлванчигдорж, Х.Пэрлээ, Ш.Нацагдорж, Н.Жагварал, Ц.Насанбалжир, Г.Сүхбаатар, Д.Гонгор, Х.Дашдондов, П.Лувсандорж, С.Лувсандорж, Ю.Адъяа, Т.Намжил, Д.Гүрбазар, М.Төмөржав, Н.Эрдэнэцогт, Д.Цэрэндулам, Х.Эрдэнэжав, Ю.Индра, О.Шагдарсүрэн, Д.Төмөртоогоо, С.Амгаа, Ц.Цэрэндаш нарын олон эрдэмтэд бэлчээр нутгийг янз бүрийн хэлбэрээр судлан өөрсдийнхөө бүтээлүүдэд тусгасан байна.

Манай орны газар эдэлбэрийн хамгийн түгээмэл байдал нь бэлчээрийн хэлбэрээр нутгаа эзэмшдэг явдал юм. Монголын малчид бэлчээрийг ашиглахдаа газар зүй, цаг уур, улирлуудын өөрчлөлт халуун хүйтний хэлбэлзэл, ургамалан бүрхэвч, усан хангамжтай мал сүргээ уялдуулж жилийн улирлуудын нутаг буюу зуслан, намаржаа, өвөлжөө, хаваржааг олон жилийн ажиглалт судалгаа, туршилтын үр дүнд буй болгодогдгоос гадна, зарим газарт малаараа тандаж нутгаа тогтоодог.

Иймд дөрвөн улирлын бэлчээр нутаг нь Монгол түмний оюуны болон материалын соёлын үнэт зүйлс болоод зогсохгүй дэлхийн бэлчээр, нүүдлийн мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд Монголчуудын оруулсан асар их хувь нэмэр гэж үзэх үндэстэй.

Манай орны хөдөө аж ахуйн эдэлбэр газарт хамгийн их хувийн жин дардаг бэлчээр нутаг түүний ашиглалтын байдлыг судлахдаа БНМАУ-ын Хөдөө аж ахуйн яамны газар зохион байгуулах хэлтсээс 1975 онд албан ёсоор тогтоож одоог хүртэл мөрдөж байгаа бэлчээрийн 115152000 га талбайг мал бүхий өрхөд оногдох хэмжээг судалгаандаа ашигласан болно.

Хүснэгт 1

Мал бүхий нэг өрхөд оногдох бэлчээр нутгийн талбай

Онууд	Малтай өрхийн тоо	Малтай нэг өрхөд ноогдох бэлчээр нутаг (га-р)
1940	209900	548
1965	183800	626
1990	262300	439
1995	283900	405
1996	289100	398
1997	294300	391
2003	236210	488
2004	229437	502
2005	225391	510
2006	225366	511

Бидний энэ судалгаанаас үзэхэд 1940 оныхоос өрхийн тоо 1965онд 12.4 хувиар буурсан нь 1959онд нэгдлийн мал аж ахуйг хөдөлмөр зохион байгуулалтын нэгж болох сууриар малын төрлөөр төрөлжүүлэн зохион байгуулсантай холбоотой. Хөдөө аж ахуйн нэгдлийн мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалт, хөлс төлөлтийн тухай Намын төв хороо, Сайд нарын зөвлөлийн 1963 оны 220/330 дугаар тогтоол нь суурь зохион байгуулалтын үндэс нь болж байсан бөгөөд суурийг малын төрлөөр бүс тус бүрээр ялгаатай зохион байгуулж байсан юм. Мал бүхий өрхийн тоо 1965 оныхоос 1990онд 25-н жилийн хугацаанд 42 хувиар огцом өссөн нь 1987оноос манай улсын хөдөө аж ахуйн нэгдлүүдийн малчдын дунд түрээсийн гэрээ өргөн хэрэглэж гэрээнээс давсан малыг аминд шууд өгдөг болсон нь сууриуд задарч мал аж ахуй эрхлэх сонирхол буй болж хот сууринд тодорхой ажилгүй буюу улирлын шинж чанар бүхий ажил эрхэлдэг хүмүүс мал аж ахуйд шилжих явдал ихэссэнтэй холбоотой юм

гэж үзэж байна. Гэрээ, түрээсийг мал аж ахуйд хэрэглэсэн явдал нь хоршооллын өмч хөрөнгө мөн чанартаа төрийн мэдэлд төвлөрч нэг төвөөс зохицуулан хэт төвлөрсөн өмчийг зохих хараа хяналт, зохион байгуулалттай задлах, малчдын идэвх сонирхолыг хөндсөн дэвшилттэй арга хэмжээ байсан юм. Гэтэл энэ ажлыг 1992 онд бүр мөсөн зогсоож нийтээр хувьчлалт болгон хувиргасан юм. Нэгдлийн мал хувьчлал дутагдалтай болж зөвхөн малыг малчдад хувааж бусад хөрөнгийн ашиглалтыг харгалзаагүй юм. Одоо малчин өрхийн 70 гаруй хувь нь 100 хүрэхгүй, 10 орчим хувь 200 хүртэл толгой малтай байгаа нь хөдөөд баян, хоосны ялгаа гүнзгийрч байна.

Хөдөө аж ахуйн эдэлбэр газар, түүн дотроо бэлчээрийн талбайн ашиглалтад мал бүхий өрхийн тооны хамаарал өндөр бөгөөд манай улсын 1940 оноос хойш 2006 оныг хүртэлх сүүлийн 66 жилийн хугацааны мал бүхий өрхөд оногдох бэлчээрийн талбайн байдлыг авч үзлээ.

Бэлчээрийг ашиглах үндсэн субъект нь малчин өрх боловч бэлчээрийн талбайн ашиглалтыг тооцох нь бэрхшээлтэй. Нэг хотонд байх айлын тоо, мөн малын тоо харилцан адилгүй байна. Иймд тогтвортой хэмжигдэхүүн болох мал бүхий өрх айлын тоогоор бэлчээрийн талбайн байдалд судалгаа хийж нэг өрхөд ноогдох бэлчээрийн талбай гэсэн үзүүлэлтээр бэлчээр ашиглалтын байдлыг авч үзлээ. Ингэж үзвэл 1940 онд мал бүхий нэг өрхөд 548га, 1965 онд 626га, 1990 онд 439га, 1995 онд 405га, 2006 онд 511га тус тус байна. Мал бүхий өрхийн тоотой бэлчээр нутгийн талбайн хэмжээ судалгаанаас үзэхэд урвуу хамааралтай ажээ.

Дээрх судалгаагаар мал бүхий өрхөд оногдох бэлчээр, нутгийн хэмжээг илэрхийлсэн бол мал бүхий өрхөд оногдож буй малын тоо дараах байдалтай байна.

Хүснэгт 2

Малтай өрхөд ноогдож буй малын тоо

Онууд	Малтай өрхийн тоо	Өрхөд ногдох малын тоо	Үүнээс				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
1940	209900	124	3	11	13	73	24
1965	183800	129	4	13	11	75	26
1990	262300	180	2	9	11	58	20
1995	283900	100	1	9	12	48	30
1996	289100	102	1	10	12	47	32
1997	294300	106	1	10	12	48	35
2003	236210	107	1	8	7	46	45
2004	229437	122	1	9	8	51	53
2005	225391	135	1	9	9	52	59
2006	225366	155	1	10	10	66	68

1940 оноос 2006 он хүртэлх 66 жилийн хугацаанд нэг өрхөд оногдох малын тоо өсч, буурч байсан нь тухайн үед төр, засгаас явуулж байсан бодлого гэхээсээ илүү байгаль цаг уур ялангуяа ган зудын уршиг ихээр нөлөөлж байжээ гэх үндэстэй.

Малчин болон мал бүхий өрх аж ахуйтнуудын үйлдвэрлэлийн гол хэрэгсэл нь бэлчээр нутаг, мал сүрэг юм. Бэлчээр нүүдлийн мал аж ахуйн нөхцөлд малчин нэг өрхөд оногдох бэлчээр нутгийн талбай нэмэгдэх тусам уг аж ахуйн үйл ажиллагаанд эерэг нөлөөтэй байдаг. Учир нь соргог нутаг их байх тусам бэлчээрийг сорчлон малаа хариулж тарга хүч сайн авахуулах нь ашиг шим арвин авахын үндэс болдог. Иймд бид хонин толгойд шилжүүлсэн малд болон малчин өрхөд оногдож буй бэлчээрийн талбайг судалгаандаа хамруулсан юм. (хонин толгойд шилжүүлэхдээ тэмээ -5, адуу -7, үхэр -6, хонь -1, ямаа -0.9 гэсэн коэффициентийг ашигласан)

Хүснэгт 3

Хонинд шилжүүлсэн малын тоонд ногдох бэлчээр нутгийн талбай

Онууд	Мал бүхий нэг өрхөд оногдох бэлчээр, нутгийн талбай	Нэг хонин толгойд ногдох бэлчээрийн	Нэг өрхөд ногдох хонин толгойд шилжүүлсэн мал				
			Бүгд	тэмээ	адуу	үхэр	хонь
1940	548.6	2.07	265	15	77	78	73
1965	627.0	2.28	275	20	91	66	75
1990	438.6	2.04	215	10	63	66	58
1995	404.2	1.88	215	5	63	72	48
1996	401.4	1.8	223	5	70	72	47
1997	390.4	1.72	227	5	70	72	48
2003	475	2.5	190	5	56	42	46
2004	494.5	2.3	215	5	63	48	51
2005	510.4	2.2	232	5	63	54	57
2006	524	2.0	262	5	70	60	66

Хонин толгойд шилжүүлсэн мал нэг өрхөд 190-275 толгой ногдож байна. Мал бүхий нэг өрхөд бэлчээр нутгийн талбай 390.4-627га газар буюу нэг хонин толгойд 1.72-2.5га оногдож байгаа үзүүлэлттэй байна.

Малчин өрх аж ахуйтны бэлчээр нутгийг эзэмшиж ашиглах үндсэн хэлбэр нь хот айл юм.

Хот айл бүрдэх явц нь ямар нэг урьдчилсан зохион байгуулалт, төлөвлөлт үгүй мал нь бэлчээрээ дагаж, малчид нь малаа даган нүүдэллэн аж төрөх явцад аандаа бүрэлдэж тогтдог зүй тогтол бүхий бөгөөд тодорхой хугацаанд аж ахуйгаа хөтлөн явуулахад зориулагдсан.

Хөдөлмөрийн энгийн хоршилт дээр үндэслэгдсэн, хөдөлмөр зохион байгуулалтын нэгэн хэлбэр мөн юм.

Бидний хийсэн судалгаагаар хот айлын бүрдэлт нь нэлээд хэдэн янз бүхий байв. Тухайлбал: эцэг, эхтэйгээ, эцэг эх төрөл садантайгаа, эцэг эх төрөл садан танилынхантайгаа, төрөл садан танилынхантайгаа, танилынхантайгаа байгаа болон өөрөөсөө бүрдэж буй хот айл гэсэн зургаан хэлбэр түгээмэл байдаг. Хот айл бүрэлдэхэд нөлөөлдөг хүчин зүйлс нь малын төрөл нь ижил учир бэлчээрээ даган айлсах эсвэл ааш зангаа авалцсан, мөн ажил төрлөө гүйцэтгэхэд гар нийлэн ажилладаг танил тал дээр үндэслэгдсэн байдаг байна.

Хот айлын бэлчээр нутгаа ашигладаг үндсэн хэлбэр нь жилийн улирлын аясыг дагаж нүүдэллэх явдал юм. Нүүдлийн талаар манай судлаачид олон талаас нь тайлбарлажээ. Эрдэмтэн М.Төмөржав, Н.Эрлэнэцогт нар <<нүүдэл нь экологийн нэг орчноос экологийн нөгөө нэг орчинд шилжих хөдөлгөөн>> гэж биологи талаас нь тодорхойлсон бол судлаач Д.Төмөргогоо <<Бэлчээр, мал, улирал гурвын зөрөөг нүүдэллэж шийдвэрлэдэг учир Монголчууд нүүдэлчин болжээ.>> гэж тодорхойлжээ.

Бидний үзэж байгаагаар бэлчээрийн монгол малын ашиг шим нь байран нөхцөлийн зардлыг нөхөөд хуримтлал буй болгох чадваргүй. Иймд хямд зардалтайгаар байгалийн бэлчээрийг ашиглан экологийн унаган орчинд малын ашиг шимийг буй болгох нөхцөлийг бүрдүүлдэг арга нь нүүдэл мөн гэж үзэж байна. Чухамдаа газрын шимийг малаараа дамжуулан хүртэж ирсэн Монгол арга юм.

Газарзүй, цаг уурын дараах бүсүүдэд малчин өрхийн нүүдэл, суудал, бэлчээр нутгийн ашиглалтыг бид судлахад дараах байдалтай байлаа.

Малчдын нүүдэл, бэлчээр нутаг ашиглалт

Бүсүүд	Хот айлын өрх гэрийн тоо	өвөл				хавар				зун			
		Хот айлын тоо	Нүүсэн тоо	өвөлжсөн хугацаа	Нүүдлийн зай (км)	Хот айлын тоо	Нүүсэн тоо	Хаваржсан хугацаа	Нүүдлийн зай (км)	Хот айлын тоо	Нүүсэн тоо	Зуссан хугацаа (хоногоор)	Нүүдлийн зай (км)
Хээр	63	30	30	134	12.2	30	39	64	7.3	30	67	91	13.7
Ойт хээр	151	40	40	134	7.8	35	35	72	7.1	30	48	96	11.2
Өндөр уул	38	25	26	116	36	22	52	80	37	22	51	85	50
Говь	50	44	44	94	14.3	33	46	75	16.7	32	78	83	29.3
Дүн	302	139	140	478	70.3	120	172	295	68.1	114	244	355	104
Дундаж			35	120	17.6	30	43	74	17	29	61	89	26.1
Бүсүүд	Намар				Жилийн дундаж								
	Хот айлын тоо	Нүүсэн тоо	ННамаржсан хугацаа	Нүүдлийн зай (км)	Хот айлын тоо	Нийт нүүдлийн тоо	Нэг хот айлын нүүсэн тоо	Нэг бууринд байсан тоо(хоногоор)	Нүүдлийн зай (км)				
Хээр	30	48	69	10.9	30	165	6	61	44.1				
Ойт хээр	30	45	63	8.3	35	186	5	73	34.4				
Өндөр уул	21	45	84	60	23	174	8	46	183				
Говь	34	38	113	14.4	32	206	6	52	76.7				
Дүн	115	176	329	95.5	120	731	25	232	338.1				
Дундаж	29	44	82	23.9	30	182	6	58	84.5				

Бидний хийсэн судалгаанаас үзэхэд хээрийн бүсийн 30 хот айлын 3 хот айл нь тус бүр 3 малчин өрхөөс, 27 хот айл нь 2 малчин өрхөөс бүрдсэн байна. өвөлжөөндөө буусан 30 хот айл бүсийн хэмжээгээр дунджаар 134 хоног өвөлжөөндөө байснаар ажиглалт явуулахад 12.2км нүүдэл хийсэн юм. Судалгаанаас үзвэл өвөлжөөндөө бууснаас хойш хот айлууд нүүгээгүй байгаа бөгөөд үүнийг хээрийн бүсийн өвөлжөөний бэлчээрийн даацтай холбон үзэж байна. Энэ бүсийн хот айлууд хаваржаандаа 7.3км нүүдэл хийж, 30 хот айл 39 удаа нүүж 68 хоног хаваржаанд байлаа. Эдгээрээс 21 хот айл нэг хаваржаандаа, 9 хот айл хоёр хаваржаанд нүүдэллэн хаваржсан байна. Хээрийн бүсийн зуслан нь сэрүүн дэнж бүхий ялаа шумуулгүй газарт байршиж байв. Судалгаанд хамрагдсан хот айлууд 13.7км нүүдэл хийн зусландаа гарсан. 12 хот айл нэг зусланд, 18 хот айл хоёр зусланд нүүдэл хийсэн бөгөөд энэ бүсийнхэн дунджаар 91 хоног зусланд байв. Эдгээр хот айлууд намаржаалахын тулд 10.8км 69 хоног намаржсан байна. Судалгаанд хамрагдсан хээрийн бүсийн 30 хот

айл жилдээ 165 удаа нүүдэл хийсний 96 удаагийн буюу жилийн нүүдлийн 58.2% нь зун намрын улиралд хамрагдаж байгаа нь соргог сайн бэлчээрийг сонгон малдаа тарга хүч авахуулсантай холбоотой байна. Хээрийн бүсийн нэг хот айл жилд дунджаар 6 удаа нүүж нийтдээ 44 км зайд нүүдэл хийж байв.

Ойт хээрийн бүсийн 40 хот айл 151 малчин өрхийг хамарсан судалгаа хийхэд тэдгээр хот айлууд өвөлжөөндөө дунджаар 7.8 км нүүсэн нь 40 хот айл нэг өвөлжөөндөө дунджаар 134 хоног өвөлжсөн байна. Энэ бүс нутгийн 35 хот айлын 35 нь хаваржаандаа дунджаар 7.1 км зам туулан нүүдэллэж 72 хоног хаваржсан байна. Үүнээс үзэхэд ойт хээрийн бүсэд зөвхөн хаваржаандаа нүүж буухаас өөр нүүдэл хийхгүй байгаа нь газар зүй, цаг уурын нөхцөлтэй холбоотой байлаа. Учир нь өвлийн улиралд цас нэлээд ордгоос хаваржааны бэлчээр цасандор нооцлогдон үлддэг тул хаварт бэлчээр хүрэлцээтэйгээс хаваржаа сэлгэн нүүдэллэх нь ховор байна.

Зун энэ бүсийн 30 хот айл 67 удаа нүүснээс 23 хот айл 2 зусланд, 7 хот айл 3 зуслан дамжиж зуссан байна. Зусланд 11.2 км нүүдэл хийсэн ба 96 хоног зуссан байна. Энэ бүс нутгийн зуслангийн нүүдэл хамгийн богино зайтай байгаагаараа онцлог юм. Ойт хээрийн бүсийн намаржааны байдлыг авч үзвэл 30 хот айл 45 удаа нүүдэл хийсэн бөгөөд 20 хот айл нэг, 5 хот айл нь хоёр, мөн 5 хот айл гурван намаржаа дамжин дунджаар 8.3 км нүүж 63 хоногийг намаржаанд өнгөрөөжээ. Ойт хээрийн бүсийн 35 хот айл жилдээ 186 удаа нүүсэн нь нэг хот айл дунджаар жилд 5 удаа нийтдээ 34.4 км нүүдэл хийж байгаа нь бусад бүс нутгаас цөөн байгаа бөгөөд энэ нь бэлчээрийн хүрэлцээ даацтай холбоотойг дахин нотолж байна.

Өндөр уулын бүсийн судалгаанд 25 хот айлын 38 айл гэр 26 удаа нүүсэн бөгөөд өвлийн улиралд дунджаар нэг хот айл 36 км нүүж өвөлжөөндөө хүрдэг ба 24 хот айл нэг өвөлжөөндөө, нэг хот айл 2 өвөлжөө дамжсан байна. Хаваржаанд 22 хот айл 52 удаа нүүдэллэсэн 14 хот айл 2, 8 хот айл 3 хаваржаа дамжин нутагласан байна. Хаваржаанд дунджаар 80 хоног байжээ. Энэ бүс нутагт хаврын цагт нэг хот айл дунджаар 37 км нүүдэллэсэн нь жилийн бусад улирлаас харьцангуй бага байгаа нь энэ үе бог малын төл бойжуулах үетэй давхцдаг бөгөөд нялх төлтэй мал нүүдлийн зам туулах чадвар муу байдагтай холбоотой. Иймэрхүү байдал ихэнх бүс нутагт ажиглагдаж байна.

Зуны улиралд 22 хот айл 51 удаа нүүдэллэсэн бөгөөд 1 хот айл дунджаар 50 км зам туулан зусландаа гарснаас 15 хот айл 2, 7 хот айл 3 зуслан дамжин зуссан байна. Энэ бүсийн хот айлууд 85 хоног зусландаа байжээ. Намаржаанд энэ бүсийн 21 хот айл 45 удаа нүүж 18 хот айл 2, 3 хот айл 3 намаржаа дамжин намаржсан байна. Энэ бүсийнхэн намаржаандаа 60 км нүүж 84 хоног намаржсан байна.

Өндөр уулын бүсийнхэн жилд дунджаар 8 удаа нүүдэг нь бусад бүс нутгаас хамгийн их нүүж байгаа нь энэ бүсийнхэн өндөр уулсын дунд болон дээд бүслүүрт зусаад намарт голын хөндий, нууруудын хотхор хүртэл нүүж намаржаад эргэж уулсын дунд хэсгийн эвэр ам хөндийд өвөлжиж хаварждагтай холбоотой гэж үзэж байна. Бидний судалгаа бусад (Доктор Д.Базаргүр болон бусад) судлаачдын судалж гаргасан дүгнэлттэй зарим талаар таарч байгааг тэмдэглэж байна. Энэ бүс нутгийн жилийн нүүдлийн урт дунджаар 183 км-т хүрч бусад бүсүүдээс 106.3-148.6 км-ээр их байгаа нь газарзүйн байршилтай холбон тайлбарлаж байна.

Говийн бүсийн судалгаанд 44 хот айл 50 өрх гэр хамрагдсан бөгөөд өвөлжөөнд 44 хот айл дунджаар 14.3 км нүүсэн байна. Эдгээр хот айлууд нэг өвөлжөө дамжин өвөлжжээ. Говийн бүсийнхэн дунджаар 94 хоног өвөлжсөн байна. Хаврын цагт 33 хот айл 46 удаа нүүсэн нь 20 хот айл 1, 13 хот айл 2 хаваржаа дамжин 94 хоног хаваржиж энэ хот айлууд дунджаар 14.3 км нүүдэллэжээ. Зуны улиралд судалгаанд хамрагдсан 32 хот айл 78 удаа нүүдэллэсэн нь 18 хот айл 2, 14 хот айл 3 зуслан дамжин зуссан байна. Зусланд гарахдаа 29.3 км зам туулж нийтдээ 83 хоног зусжээ.

Говийн намар их тогтуун болдог нь малчдын нүүдэлд хүртэл нөлөөлдөг байна. Тухайлбал 34 хот айл 38 удаа нүүсэн нь 30 хот айл нэг намаржаанд, 4 хот айл 2 намаржаа дамжсан байна. Бусад бүс нутагт намар дунджаар 1-2 удаа нүүх байдал ажиглагдаж байгаа юм. Чухамдаа говийн бүсийнхэн 113 хоног намаржсан нь бусад бүсүүдээс 29-50 хоногоор урт байгаа нь дээрхийн баталгаа болж байна. Намаржаанд дунджаар 16.4 км нүүдэл хийсэн байна. Говийн бүсийнхэн жилд 7 удаа дунджаар 76.7 км нүүдэл хийдэг нь өндөр уулын бүсийн дараа орох үзүүлэлт болж байна.

Оноогийн зах зээлийн ханшаар мал аж ахуйн салбарт буй болдог зарим бүтээгдэхүүний үнэнд үндэслэн дундаж малчны өрхийн орлогыг тооцож үзсэн юм.

Хүснэгт 5

Мал аж ахуйн зарим бүтээгдэхүүний үнэ

д/д	Мал аж ахуйн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Нэгж бүтээгдэхүүний үнэ (төгрөгөөр)
1.	Тэмээний ноос	кг	5000
2.	Тэмээний ноос	кг	2500
3.	Бодын хөөвөр	кг	2000
4.	Бодын хялгас	кг	2000
5.	Сүү	л	600
6.	Хонины ноос	кг	400
7.	Хурганы ноос	кг	500
8.	Ямааны ноолуур	кг	35000
9.	Ямааны ялгас	кг	300
10.	Айраг	л	700
11.	Мах	кг	3000

Эндээс зах зээлийн дундаж үнэнд тулгуурлан малчин өрхийн орлогыг тооцож үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 6

Малчин өрхийн хонин толгойд шилжүүлсэн мал аж ахуйгаас орох жилийн дундаж орлого

Онууд	Дундаж орлого				
	Нэг малчин өрхөд оногдож буй бэлчээрийн талбайд оногдох		Нэг хонин толгойн талбайд оногдох	Нэг га бэлчээрийн талбайд оногдох	
1940	1264190		4770,53	2304,39	
1965	1159410		4216,03	1849,14	
1990	996800		4636,28	2272,69	
1995	1205570		5607,30	2982,61	
1996	1235850		5541,93	3078,84	
1997	1262390		5561,19	3233,58	
2003	957050		5037,11	2014,84	
2004	1140150		5303,02	2305,06	
2005	1348970		5814,52	2642,97	
2006	1456150		5557,82	2779,48	
Онууд	Хонин толгойд шилжүүлсэн малын төрөл, түүний орлого				
	тэмээ	Адуу	үхэр	хонь	ямаа
1940	63750	216400	603600	119960	260480
1965	201750	147200	453200	103000	254260
1990	42500	215600	453200	81360	204140
1995	21250	215600	603200	69920	295600
1996	21250	216400	603200	69400	325600
1997	21250	216400	603200	69600	351940
2003	21250	109800	302000	65600	458400
2004	21250	215600	302400	71160	529740
2005	21250	215600	452400	80840	578860
2006	21250	216400	452800	88160	677540

Энэ судалгаанаас үзэхэд малчин нэг өрхийн нэг жилд эзэмшиж буй бэлчээрийн нийт талбайд 957050-1456150 төгрөгийн бүтээгдхүүн үйлдвэрлэж байгаа ба нэг хонин толгойд оногдох бэлчээрийн талбайгаас жилд 4216,03-5814,52 төгрөгийн оролого олж байгааг бидний судалгаа нотлов. Мөн тэрчлэн судалгааны хамрагдсан хугацааны дотор бэлчээрийн нэг га талбайд жилд 1849,14-3233,58 төгрөгийн бүтээгдхүүн үйлдвэрлэж байна. Үүнээс үндэслэн Монгол улсад одоо албан ёсоор мөрдөж буй 115152000 га бэлчээрийн талбайд нэг жилд 212,9-378,4

$(115152000 \cdot 1849,14) = 212.932.169.280$ төгрөг

$(115152000 \cdot 3233,58) = 372.353.104.160$

Тэрбум төгрөгийн бүтээгдхүүн үйлдвэрлэж байгааг бидний судалгаа харуулж байна. Ийм зүйлийг бүтээх гол ажил нь мал харуулж

бэлчээрлүүлэх явдал юм. Эх газрын эрс тэс уур амьсгалтай хүнд нөхцөл дэх Монголын малчин өрхийн айлын маллаж буй буй малын төрөл тус бүрийн бэлчээрийн алслалт болон бэлчээрлэлт нь ч өөр өөр, улиралаар ч ялгаатай байна. Бид судалгаандаа мал нэг өдөрт бэлчих зай, нэг буурин дээр шаардагдах бэлчээрийг тооцон дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 7

Мал нэг өдөрт бэлчих зай, нэг буурин дээр шаардагдах бэлчээр


Л/д	Малын төрөл	Өдрийн бэлчээрийн алслалт /км-ээр/				Нэг бууринд шаардагдах бэлчээрийн талбай /кв.км-ээр/	
		Зун Намар	Өвөл Хавар	Дундаж зай Зун Намар Өвөл Хавар		Зун Намар	Өвөл Хавар
1	Тэмээ	4,0-6,0	2,5-3,8	5	3,2	79,3	32,5
2	Адуу	3,0-23,0	2,8-7,3	13	5	535,7	79,3
3	Үхэр	3,8-5,0	2,6-2,9	4,4	2,8	61,2	24,9
4	Бог мал	3,0-5,0	2,0-3,0	4	2,5	50,7	19,8

Хүснэгтээс үзэхэд зун, намар адууны бэлчээрийн алслалт 23 км байхад бог малынх 3 км байгаа ба энд тэмээ, үхрийн бэлчээр хамрагдаж байна. Гэхдээ хонь, ямаанаас бусад малын бэлчээр өөр өөр байдаг онцлогтой. Өвөл хаврын улиралд бог 2 км, адуу 7,3 км байгаа нь хамгийн ойр болон холын бэлчээрийг илэрхийлж байна. Судалгаанаас үзэхэд зун, намрын бэлчээрлэлтийн алслалтаас өвөл, хаврын бэлчээрийн алслалт багасч байна. Тухайлбал тэмээ 1,5-2,2 км, адуу 0,2-15,7 км, үхэр 1,2-2,1 км, бог мал 1-2 км-ээр бэлчээрийн радиус буурч байна. Үүнтэй уялдан бэлчээрлэх талбайд ч өөрчлөлт гарч байна. Тухайлбал тэмээний зун, намрын бэлчээрлэх талбайгаас өвөл хаврын бэлчээрлэлтийн талбай 58,9 хувь, адуунд 85,2 хувь, үхэрт 59,6 хувь, бог малд 61 хувь тус тус буурч байгаа нь судалгаанаас харагдаж байна. Үүнээс үзвэл зун, намрын улиралд бэлчээрийн алслалт их байгаа нь өдрийн үргэлжлэх хугацаа их, энэ нь малын тарга тэвээрэг авах, ашиг шим бүрдэхэд сайнаар нөлөөлж байна.

Энэ үеийн бэлчээрийн ургамал шим шүүс сайтай байдаг үе юм. Харин өвөл, хаврын улиралд өдрийн үргэлжлэлт богинохон болохоор бэлчээрт байх хугацаа бага, бас цас шуурга болон байгалийн гэнэтийн аюулаас сэргийлэн ойр бэлчээрлүүлэхтэй холбоотой.

Улсын хэмжээгээр бүх бэлчээрийн 4,6 хувь нь өндөр уулын бүсэд, 22,9 хувь нь ойг хээрийн бүсэд, 28,3 хувь нь цөлөрхөг бүсэд, 16,2 хувь нь цөлийн бүсэд ноогдож байна. Бэлчээрийн өвс ургамал улирал бүрд харилцан адилгүй байдаг. Энэ нь малын бэлчээрийн тэжээлийн хэмжээ харилцан адилгүй байхын үндэс болж байна. Манайд бэлчээрийн талбайн 42 хувийг зун, намар, 58 хувийг өвөл, хавар ашиглаж байна. Жилийн аль ч улиралд байнга хотолж, малладаг сүрэг нь бог мал юм. Бог малын зун намрын улиралд нэг буурин дээр 50,7 кв.км өвөл хаврын улиралд 19,8 кв

км талбайд бэлчээрлэдэг. Энэ үед 3-4 хот айл усаа түшиглэн ойролцоо байрлах явдал элбэг байдаг бөгөөд үүнээс үүдэн сөрөг үр дагавар бараг гардаггүй. Гэвч талбайн давхцалын байдлыг заримдаа нарийн тооцож бэлчээрийн даацыг тодорхойлох шаардлага амьдралаас гардаг. Иймд дараахь аргачлалаар тооцож засвар хийх боломжтой.



$$AB=b \text{ бол } S_c = \frac{4}{3}bh + \frac{h^3}{b};$$

Энэ аргачлалар давхцыг зөрүүг аль нэг талд шингээж нөгөөгөөс хасах эсвэл давхцсан талуудын тоонд тэнцүү хувааж тус бүрээс хасах замаар тооцож болно.

Малын бэлчээрт идээшлэх нь эдийн засгийн утгаараа газрын өгөөжийг бүтээгдхүүн болгон хувиргах процесс юм. Энэ нь бэлчээрлэлтийн хугацаатай нягт холбоотой.

Иймээс хоногт мал бэлчээрлэх болон хотондоо байх хугацааг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 8

Улирлууд	Тэмээ				Адуу			
	Бэлчээрлэлт	Үүнээс		Хотлолт	Бэлчээрлэлт	Үүнээс		Хотлолт
		Идэшлэлт	Ус уух, сул явах, амрах			Идэшлэлт	Ус уух, сул явах, амрах	
Зун намар	11,5-16,5	8,5-11,5	3-5,0	7,5-12,5	12,8-14,7	12,8-14,7	0,2-0,7	9,3-11,2
Өвөл, хавар	10,3-13,4	7,3-8,4	3-5,0	10,6-13,7	16,8-19,1	16,8-19,1	0,2-0,6	4,9

Улирлууд	Үхэр				Бөг мал			
	Бэлчээрлэлт	Үүнээс		Хотлолт	Бэлчээрлэлт	Үүнээс		Хотлолт
		Идэшлэлт	Ус уух, сул явах, амрах			Идэшлэлт	Ус уух, сул явах, амрах	
Зун намар	14	9	5	10	13-15	9,1-10,5	3,9-4,5	9,0-11,0
Өвөл, хавар	11	8	3	13	8	5,6	2,4	16

Малын хоногт бэлчээрлэх болон хотондоо хэвтэх байдлаас үзэхэд бэлчээрт идэшлэх хугацаа зун, намрын улиралд урт, харин өвөл хаврын цагт зун, намрынхаас тэмээнд 1,2-3,1 цаг, үхэрт 1 цаг, бөг малд 5-7 цагаар буурч, харин адуунд өвөл, хаварт идэшлэх хугацаа 4 цагаар нэмэгддэг байлаа.

Бэлчээрээс малын өдөрт идэх өвс ногооны хэмжээ нь малын бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, ашиг шимд нөлөөлөх үндсэн хүчин зүйл юм. Эрдэм шинжилгээний байгууллагууд бэлчээрээс хонины өдөрт идэх тэжээлийн хэмжээг энергийн бодисын тусламжтайгаар тодорхойлж үзэхэд бүсийн онцлогоос хамааран хонь зуны улиралд 1,4-1,7 кг ногоо, намар 1,7-2,4 кг таваг сөлтэй хагд өвөл, хаврын улиралд 1,0-1,4 кг өвс идэж байгаа нь зуны өдөрт шаардагдах нормоос 0,83 тэжээлийн нэгж, 60 гр шингэх протеин илүү авч, харин өвөл, хаврын нормоос 0,29-0,40 тэжээлийн нэгж, 40-48 гр шингэх протеин дутуу идэж байжээ.

Зун, намар өндөр уул, хээрийн бүсийн бэлчээрээс ямааны идсэн ногоог хониныхтой харьцуулахад 9,4 хувь, өвөл, хавар 25 хувь доогуур байхад говийн бүсэнд зун, намар 22 хувь, өвөл, хавар 20 хувь дээгүүр байгаа нь говийн бүсэд ямааны дуртай сөөг, сөөгөнцөр ургамал элбэг ургадагтай холбоотой юм.

Зун, намрын улиралд хонины хоногт идсэн тэжээлийн хэмжээг тэмээнийхтэй жишихэд өвс 10,6, ногоо 6,6 дахин бага, адууныхаас дээрхи дарааллаар 14,0; 6,3; үхрээс 5,5; 6,3 дахин бага байна. Бэлчээрийн мал сүрэг зун намрын улиралд бие махбодын шаардлагат шимт бодисыг бэлчээрээс бүрэн авч байгаа учраас богино хугацаанд тарга хүч авч харин өвөл, хаврын улиралд бэлчээрийн ургамлын бодисийн төгс бус чанартай уялдан хонь нас хүйс, бүсийн онцлогоос хамааран намрын жингийнхээ 6,9-34,4 хувь, тэмээ 11,8-21,1 хувь, үхэр 8,4-23,3 хувийг алдаж байна. Үүнээс үндэслэн өвөл, хаврын улиралд бэлчээрээс хоногт идэж байгаа тэжээл нь идвэл зохих нормт тэжээлийн 40-50 хувь, шингэх протеины 30-33 хувийг хангадгийг манай орны мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судалгаа баталж байгаа юм.

Малчин өрхийн аж ахуй дахь хамгийн чухал зүйл бол малчны хөдөлмөр зарцуулалт юм. Энэ асуудлыг хөндөж бид малчин өрхийн ажлын ачааллыг ажлын өдрийн зураг авалтаар харуулав.

Хүснэгт 9

Малчин өрхийн ажлын өдөр

Бүсүүд			Хээр	Ойт хээр	Өндөр уул	Говь	Дундаж	
Ажлын өдрийн үргэлжлэл	Гэрийн эзэн	Дулааны улиралд	Өглөө босдог цаг	5 ³⁰	6 ⁰⁰	6 ⁰⁰	5 ⁴⁵	-
			Орой унтдаг цаг	21 ³⁰	24 ⁰⁰	23 ⁰⁰	23 ³⁰	-
		Ажлын өдрийн үргэлжлэлт		16	18	17	17.35	17
		Хүйтний улиралд	Өглөө босдог цаг	8 ⁰⁰	7 ⁰⁰	5 ³⁰	7 ⁰⁰	-
			Орой унтдаг цаг	22 ⁰⁰	22 ⁰⁰	22 ⁰⁰	22 ⁰⁰	-
		Ажлын өдрийн үргэлжлэлт		14	15	16.3	15	15.1
	Гэрийн эзэгтэй	Дулааны улиралд	Өглөө босдог цаг	5 ³⁰	6 ⁰⁰	5 ³⁰	5 ²⁰	-
			Орой унтдаг цаг	22 ³⁰	24 ⁰⁰	23 ⁰⁰	23 ⁰⁰	-
		Ажлын өдрийн үргэлжлэлт		17	18	17.3	17.4	17.43
		Хүйтний улиралд	Өглөө босдог цаг	7 ⁰⁰	7 ⁰⁰	4 ³⁰	6 ⁴⁰	-
			Орой унтдаг цаг	22 ⁰⁰	22 ⁰⁰	22 ⁰⁰	21 ⁰⁰	-
		Ажлын өдрийн үргэлжлэлт		15	15	16.5	14.2	15.075

Дээрх ажлын өдрийн үргэлжлэлтийг авч үзвэл дулааны улиралд аль ч бүсэд гэрийн эзэн 16-18 цаг, эзэгтэй нар 17-18 цаг ажилладаг бөгөөд хүйтний улирлын үед гэрийн эзэн 14-16,5 цаг, эзэгтэй нар 15-16,8 цаг тус тус ажиллаж байна. Малчин өрхийн аж ахуйн ажлын онцлог нь цаг уур, газар зүйн бүсийн ялгаа нэг их мэдрэгддэггүй нь аль ч бүс нутаг дэх мал маллагааны технологи, мал аж ахуйн систем нэг янзын байгаатай холбон тайлбарлаж болох юм.

Бидний судалгаагаар ямар ч улирлын үед эзэгтэй нар гэрийн эзнээс 20 минутаас цагийн өмнө босч харьцангуй ижил цаг хугацаанд унтдаг байна. Гэрийн дотор энэ хоёр хүний цагийн хооронд гэрийн бусад хүмүүсийн ажлын үргэлжлэл багтдаг. Дулааны үеийн ажлын өдрийн үргэлжлэлт, хүйтэн улирлын үеийнхнээс урт байгаа нь:

1. Өдрийн үргэлжлэлт урт

2. Энэ үед малын ашиг шим авах, мал таргалуулах зэрэг амин чухал асуудлууд давхцан явагдаж байгаатай холбоотой байлаа.

Бэлчээрийн мал аж ахуйн салбар дахь малчин өрхөд л ажилд бэлтгэх, төгсгөх, технологийн тасалбал болон хувийн хэрэгцээний цагийг бид

судалгаандаа хамруулаагүй юм. Гэвч өглөөний босолт оройны унтахаар хэвтэх хооронд мал аж ахуйн болон гэрийн үйлдвэрлэлийн ажлууд шууд явагддагийн гадна дулааны улиралд усан бороо, ширүүн мөндөр хүйтний улиралд цасан шуурга, салхи шуурганы үеүдэд малчид бүгд босч гэр малын ажилд оролцдог. Үүнээс үзвэл малчны ажил нь цагаар хэмжигддэггүй хүнд ажил байдгаараа өвөрмөц онцлогтой.

Хот айлыг бүрдүүлэгч малчин өрхийн хоорондох хөдөлмөрийн хуваарь нь өдөр тутмын ажил болох бог малын хариулгыг ээлжээр гүйцэтгэх, хашаа хороо барих, худаг ус гаргах, мал ноослох, эсгий хийх зэрэгт илэрдэг. Гэрийн дотоод хөдөлмөрийн хуваарь нь хөдөлмөрийн чадвараа алдсан настай өвгөд эмгэд нь нялх хүүхдийг асарч саатуулах, тусад орсон бага насны хүүхэд хонь хурга хариулах, ус түлшинд явах, аргал түүх, томчуудын ажилд хамжаа тусыг үзүүлнэ. Бас ч томорч байгаа боловч нас биед хүрээгүй эрэгтэй хүүхэд эцгийн ажилд туслах, адуу мал ойртуулах, унага барьж гүү саалгах, даага шүдлэн зэрэг болон эмнэг хангал малыг эдэлгээнд сургах ажил гүйцэтгэнэ.

Ийм насны охид нь сүү цагаан идээ боловсруулах, гэр орноо өөд татаж цэвэрлэх, хоол унд хийх, юм оёх зэргээр эх эцгийн ажилд туслах явцдаа ажлын эвсэлд чадахгүйгээсээ чаддаг болж, мэдэхгүйгээсээ мэддэг болж өсөн торниж байдаг.

Монгол малчин өрх нь Монгол хувь хүн бүрэлдэх унаган нөхцөл, бие хүн төлөвших нийгмийн эгэл орчин мөн. Ер нь монгол хот айлыг бүрдүүлэгч өрх гэр нь малчдын нийгэм, ахуй, амьдрал соёлыг цогцлуулагч цөм юм. Гэрийн дотор нас өндөр болсон өтгөс, тусад ороогүй нялхас хоёроос бусад нь цаг хугацааны үргэлжлэн буй бүхий л ажилд хүссэн ч эс хүссэн ч татагдан ордог. Ялангуяа бага насны залуучууд амьдрал таньж төлөвшин өсч ирээдүйн малчин өрхийн эзэд болох арга замаа эзэмшдэг.

Малчин болоод мал бүхий өрх айлууд нь бэлчээр нүүдлийн мал аж ахуй эрхлэх явцдаа хоёроос дээш өрх гэрээс хот айл, хэд хэдэн хот айлаас нэг усныхан, хэд хэдэн усныхнаас нэг нутгийнхан, хэд хэдэн нутгийнхнаас буюу бидний судалгаагаар 8-12 нутгийнхнаас нэг сум буюу хөдөө дахь засаг захиргааны байгууллага бий болсон байдаг.

Нутаг нь өргөн хүрээтэй ойлголт юм. Хүмүүс нь тухайн нутгийн нөмөр дулаан, хүйтэн сэрүүн байдлыг амьдралынхаа туршлагаар таньж мэдсэн, ус, ургамал түүнийхээ хангамж хүрэлцээг жилийн улирлын ай зүйд нийцүүлэн мал сүргээ маллахдаа үр ашигтай ашиглаж чаддаг он удаан жилээр үр шимийг нь малаараа дамжуулан хүртсэн учир өөрийн гэр мэт хайрлан онголон тахиж шүтэн биширдэг, гаднын зүй бус халдлагаас хамгаалах дархлаа нутгийнхны сэтгэлд тогтсон зэрэг нь хүн байгалийг аж төрөлдөө ашиглах явцад үүсэн тогтсон харилцан шүтэлцээтэй нэгэн төрлийн нэгдэл юм.

Тиймээс ч малчин ардын дунд “Мэдэхгүй нутгийн бурхнаас, Мэддэг нутгийн чөтгөр дээр” гэсэн хэлц үг байдаг.

Тухайн нутаг усныхандаа нэр хүндтэй, ажил амьдралын баян туршлагатай, хүний мөс, хүнлэг сэтгэл сайтай тэндхийн хүмүүс

тулгамдсан болон шийдвэрлэхэд төвөгтэй асуудлаа илэн далангүй ярьж зөвлөгөө сургамж авдаг үгийг нь мөрдлөг болгож байдаг өөрийн удирдагч (Лидер)-тай, нутгийн настайчуул хэдэн үеэрээ амьдарч ирсэн энэ нутгаасаа хаашаа ч явахгүй эндээ “ясаа” тавина гэсэн сэтгэлийн хат суусан байхаас гадна нутаг усаараа хүүхэд залуучуудынхаа бурууг засаж зөвийг нь дэмжиж ирээдүй үеэ хамтаараа хүмүүжүүлдэг учирсан жаргал, зовлонгоо хуваалцаж, нутаг усныхаа нэрийг өөрийн нэрээс өндөрт өргөж явахыг эрмэлздэгээс гадна мал нь хүртэл өөр газар очвол эргэж нутагруугаа гүйтлээ ээнэгшсэн байдаг онцлогтой.

Энэ албан бус зохион байгуулалт хүмүүсийн сайн дурын сэтгэлээр бүтсэн байдаг учир бат тогтвортой мөн найдвартай холбоо байдаг.

Энэ холбоон дээр тулгуурлан бэлчээр нутаг эзэмших, малчдын холбоо нөхөрлөл байгуулбал өнөөгийн хуулийн дутагдал цоорхойг ашиглан газар нутаг сүйтгэн бузарлаж буй шунахай хүмүүсийн харгис үйлдлүүдийг зогсоон хязгаарлах нэгэн хүчин зүйл болох талтай.

Дээрх асуудлуудтай уялдан дараах дүгнэлт, санал дэвшүүлж байна.

1. Дэлхийн цаг үеийн дулааралт, хуурайшилттай холбоотойгоор бэлчээр цөлжих, хомсодоход нөлөөлж буй боловч, үүнээс илүүтэйгээр машин тэрэгний зам, уул уурхайн салбарын замбараагүй байдал, ямааны өсөлт нь монголын бэлчээрт сүйтгэлтэйгээр нөлөөлж байна.
2. Өнөөгийн бэлчээрийн талбай мал аж ахуйд хүрэлцээтэй байгаа боловч нэг малд оногдох бэлчээрийн талбай жил бүр буурах хандлагатай байна.
3. Бэлчээрийн талбайн өнгөн болон үндсэн хөрсний боловсруулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй гүйцэтгэж эхлэх шаардлагатай байна. Энэ нь бэлчээрээ эрчимжүүлэх үндэс болно.
4. Бэлчээрийн нэгж талбайд бүтээгдэж буй орлогыг нэмэгдүүлэхийн тулд мал аж ахуйг эрчимжүүлэх шаардлагатай байна.
5. Мал аж ахуйг эрчимжүүлснээр орлого хуримтлал анивжиж эргээд бэлчээрээ эрчимжүүлэх үндэс болно.
6. Бэлчээрийн талбайг үндсэн ашиглагч нутгийн малчдад эзэмшүүлж, хариуцуулан түүнд нь орон нутгийн төр захиргааны байгууллага удирдан хяналт тавьдаг байх хэрэгтэй.
7. Бэлчээр эзэмших малчдын нөхөрлөл холбоо байгуулах эрх зүйн үндсийг УИХ хэлэлцэж шийдвэрлэх хэрэгтэй байна.

Ашигласан материал

1. Альфред Маршалл. Эдийн засгийн ухааны зарчмууд. Чойбалсан хот 1997 он.
2. Адъяа.Ю. Малчин өрхийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн байдал. Монголын эдийн засаг сэтгүүл 1997 №2
3. Адъяа.Ю. Цэвээн.Ц. То вангийн сургааль дахь мал маллагааны сургамжууд. МУИС. Эрдэм шинжилгээний бичиг 1997 он. №4
4. Адъяа.Ю.Рассел.Н. Цэвээн.Ц. Монголын эдийн засаг (ХАА-н салбар) Манчестр 1999 он
5. Базаргүр.Д. БНМАУ-ын мал аж ахуйн хөгжил байршлын газар зүйн үндэс. УБ1978 он.
6. Баточир Л. Ард, анги, бүтэц, өөрчлөлт, хоршоожилт ШУА. УБ 1986 он
7. Бакей А. Бүтээмж буурах хууль. Эдийн засаг сонин 1996 №7
8. Бизъяа Г. Маркетинг УБ. 1997 он
9. Владимирцов Общественный строй Монголов (Монгольский кочевой Фейдализм) Л-д 1934
10. Гонгор Д. Халх товчоон УБ. 1978 он
11. Грайворонской ВВ. О новой революции в худоне М.а 1995
12. Гамзатов Р. Миний Дагестан. УБ 1974он
13. Жагварал Н. Аратство и аратское Хозяйство УБ. 1974 он.
14. Жагварал Н. Индра Р. Монгол орны хөдөө аж ахуйг хөгжүүлэх байгалийн нөхцөл УБ 1975 он
15. Жахан Норберг. Даяаршиж буй Капитализмийг хамгаалахуй УБ.2007 он
16. И.А. Майский Орчин үеийн монгол 2004он. УБ
17. Рашид-ад-дин. Исторические летописей М-а 1952кп-г-I
18. Төмөржав.Бэлчээрийн монгол мал УБ.2003 он
19. Статистикийн эмхэтгэл 1971. 1981. 1995. 2006. УБ
20. Эрдэнэцогт Н. Монголын нүүдлийн мал аж ахуй УБ. 1996
21. Юнатов А.А. Оснанные черты растительного покрова МНР. М.а-Л-д 1950